



ТӨВ АЙМАГ  
БОРНУУР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 07.

Борнуур

Г Төслийн сонгон шалгаруулалтын тов, Г  
Зээлийн эх үүсвэрийн дээд хэмжээг  
тогтоох тухай

Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын тов, зээлийн эх үүсвэрийн эрхийг нээлгэх сумын Засаг дарга Н.Ундрахбилэгийн саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А / 361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” - ын 2 дугаар зүйлийн 2.7, 2.10, Аймгийн Засаг даргын 2022 оны А / 94 тоот захирамжийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг 2023 оны I улиралд байхаар тогтоосугай.

2. Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд олгох зээлийн эх үүсвэрийн дээд хэмжээг 200.000.0 төгрөг байхаар тогтоосугай.

3. Зээлийн ашиглалт, эргэн төлөлт, төслийн явц үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд шаардагдах 3.441.5 мянган төгрөгийг / Гурван сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга таван зуун / хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөс зарцуулахыг сумын Засаг дарга / Н.Ундрахбилэг / - т зөвшөөрсүгэй.

4. Сангийн хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга / Н.Ундрахбилэг / - т даалгасугай.

5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30 – ны өдрийн IX хуралдааны 07 тоот тогтоолын 1 дүгээр 2 дугаар заалтыг хүчингүйд тооцсугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын / Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороон / - д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Г.ЛХАГВАДОРЖ



0011008